



МОНГОЛБАНК

ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН СУДАЛГАА

*Боловсруулсан: ВЭЗГ, ТТССХ-ийн эдийн засагч А.Цолмон
ВЭЗГ, ТТССХ-ийн эдийн засагч Ж.Сувдаа
2016 он*

ХУРААНГУЙ

Гадаад хөрөнгө оруулалтын позицййн тайлангийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд (i) банкуудын гадаад гүйлгээний 2013-2015 оны тайланд тусгагдсан гадаадын хөрөнгө оруулалтын гүйлгээний мэдээллийг холбогдох аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангаар баталгаажуулах, (ii) тус тайланд тусгагдаагүй, мөнгөн бус хэлбэрийн хөрөнгө оруулалтын мэдээллийг олж авах зорилгоор энэхүү түүвэр судалгааг зохион байгуулав.

Судалгааны асуулгыг ОУВС-гийн гарын авлага, бусад улс орнуудын туршлагад үндэслэн боловсруулж, Монгол Улсын эдийн засгийн харьяат 332 аж ахуйн нэгжид хүргүүлснээс 34% буюу 113 аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа.

Судалгааны дүгнэлтээр, одоогийн статистикт бүртгэгдсэн гадаад активын үлдэгдлийг 2013 онд **5.5** сая, 2014 онд **6.8** сая, 2015 оны эхний хагаст **11.7** сая ам.доллараар, харин пассивын үлдэгдлийг 2013 онд **141.2** сая ам, 2014 онд **189.4** сая, 2015 оны эхний хагаст **190.9** сая ам.доллараар тус тус нэмж, залруулах шаардлагатай байна.

**ГАРЧИГ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	5
1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	5
2. ТҮҮВРИЙН ОНОВЧТОЙ ХЭМЖЭЭ.....	5
3. СУДАЛГААНЫ ИРЦ.....	6
4. СУДАЛГААНЫ АСУУЛГА	7
III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	8
1. ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	9
1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	9
1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт.....	11
1.3. Өрийн хэрэгсэл.....	12
2. БАГЦЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13
3. БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	13
3.1. Худалдааны зээл	13
3.2 Зээл.....	14
3.2. Харилцах хадгаламж	14
3.3. Бусад актив, пассив	15
4. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ.....	15
IV. ДҮГНЭЛТ, САНАЛ	16
V. ХАВСРАЛТ	17

**Хүснэгтүүд**

Хүснэгт 1. Судалгааны ирц	6
Хүснэгт 2. Судалгааны нэгдсэн үр дүн	8
Хүснэгт 3. Өрийн хэрэгсэл	9
Хүснэгт 4. Хувь нийлүүлсэн хөрөнгө, улсаар	9
Хүснэгт 5. Хувь нийлүүлсэн хөрөнгө, салбараар	10
Хүснэгт 6. Орлогын дахин хөрөнгө оруулалт, улсаар	11
Хүснэгт 7. Орлогын дахин хөрөнгө оруулалт, эдийн засгийн салбараар	11
Хүснэгт 8. Орлогын дахин хөрөнгө оруулалтын үлдэгдэл	11
Хүснэгт 9. Өрийн хэрэгсэл	12
Хүснэгт 10. Худалдааны зээл	13
Хүснэгт 11. Зээл	14
Хүснэгт 12. Гадаад хөрөнгө оруулалтын позиц	15

Дүрслэлүүд

Дүрслэл 1. Эх олонлог болон түүврийн салбарын харьцуулалт	6
Дүрслэл 2. Судалгааны дүнгийн Нийт түүвэрт эзлэх хувийн жин	7
Дүрслэл 3. Хувь нийлүүлсэн хөрөнгө, улсаар	9
Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгө, салбараар	10
Дүрслэл 5. Өрийн хэрэгсэл, хугацаагаар	12
Дүрслэл 6. Өрийн хэрэгсэл, улсаар	13
Дүрслэл 7. Өрийн хэрэгсэл, салбараар	13
Дүрслэл 8. Зээл, улсаар	14
Дүрслэл 9. Зээл, салбараар	14



I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол Улсын гадаад секторын статистикийн бүтээгдэхүүнүүд болох Төлбөрийн тэнцэл, Гадаад хөрөнгө оруулалтын позиц болон Гадаад өрийн статистикийг сар, улирлын давтамжтайгаар боловсруулан нийтэд мэдээлдэг билээ.

Гадаад хөрөнгө оруулалтын позиц (ГХОП) нь тодорхой хугацааны эцэст эдийн засгийн харьяатуудын харьяат бусаас авах авлага буюу санхүүгийн хөрөнгө, харьяат буст өгөх өглөг буюу санхүүгийн өр төлбөрийг шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалт, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, бусад хөрөнгө оруулалт болон нөөц актив гэсэн үндсэн ангиллаар нэгтгэн харуулдаг статистик юм.

Дээрх статистикийг гаргах зорилгоор Монголбанк 2010 онд Гадаад хөрөнгө оруулалтын түүвэр судалгааг анх удаа 45 аж ахуйн нэгжээс авсан бөгөөд 2011 оноос эхлэн аж ахуйн нэгжүүдээс төлбөрийн тэнцлийн ТТ-1 мэдээг улирал бүр авч байна. Улс орны эдийн засаг тэлж, хөрөнгийн урсгал нэмэгдэхийн хэрээр мэдээ ирүүлдэг аж ахуй нэгжийн тоо өссөөр 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 127 аж ахуйн нэгжээс мэдээ хүлээн авч байна. Монголбанк нь аж ахуй нэгжийн мэдээг банкуудын гадаад гүйлгээний мэдээтэй нэгтгэн, статистикийг боловсруулдаг.

Статистикийн эх сурвалжийн хамрах хүрээ, нэгтгэл тооцооллын аргачлал жилээс жилд сайжирч байгаа хэдий ч статистикийн хэрэглээ, ач холбогдлыг анхааран үзээд 2015 онд түүвэр судалгааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газартай хамтран зохион байгууллаа.

Судалгаа зохион байгуулах нь цаг хугацаа, хөдөлмөр шаарддаг ажил тул түүнийг үр дүнтэй байлгахын тулд судалгааны асуулгыг боловсруулах, түүврийн хэмжээ болон оролцогчдыг сонгоход нэлээд анхаарч ажилласан. Судалгааны зорилго нь (i) одоогийн зарлагдсан статистикийн бодит байдлыг шалган баталгаажуулах, (ii) шинээр олж авсан тоон мэдээллийг статистикт тусгах, (iii) хөрөнгө оруулагч улс, хөрөнгө оруулалт хийсэн эдийн засгийн салбар, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр болон ашигт ажиллагааны байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлэхэд оршино.

Судалгааны үр дүнд Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар актив нь 11.7 сая ам.доллараар, пассив нь 190.9 сая ам.доллараар тус тус өсч статистикийн хамрах хүрээ нэмэгдэхийн хамтаар хөрөнгө оруулалтын талаар мэдээллийн санг бүрдүүлсэн давхар ач холбогдолтой боллоо.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1. Судалгааны зорилго

Сүүлийн жилүүдэд манай улсад орж ирж буй гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ, хэлбэр болон хөрөнгө оруулалт хийгдэж буй эдийн засгийн салбар 2009-2011 оны үзүүлэлтэй харьцуулахад нэлээд өөрчлөгдөж байгаа тул статистикийн бодит байдлыг шалгах, эх сурвалжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэхүү судалгаагаар статистикийн эх сурвалжийн хамрах хүрээг өргөжүүлж, банкуудын гадаад гүйлгээгээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйлгээг ААН-ийн санхүүгийн тоон мэдээлэлтэй тулган баталгаажуулж, статистикийн тоон болон чанарын үзүүлэлтийг сайжруулахыг зорилоо.

2. Түүврийн оновчтой хэмжээ

Судалгаанд 2013 оноос хойш банкны системээр хөрөнгө оруулалт, зээлийн гадаад гүйлгээг идэвхитэй хийсэн бөгөөд ТТ-1 мэдээ ирүүлдэггүй ААН-ийг хамруулав.

Гадаад гүйлгээг идэвхитэй хийсэн ААН гэдэгт (i) жилд 3 ба түүнээс дээш удаа нийт 100 мянган ам.доллараас дээш үнийн дүнтэй шууд хөрөнгө оруулалтын гүйлгээ хийсэн, (ii) 1 сая ам.доллараас дээш хэмжээний эсвэл олон удаа богино хугацаат зээлийн гүйлгээ хийсэн байх шалгуурыг тавьсан.

Өгөгдөл	Утга	Тайлбар
t	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
	0.	Тогтмол утга
N	2,525	Эх олонлог: ТЕГ-т 2014 оны тайлан өгсөн хөрөнгө оруулалттай ААН
Δ	0,05	Алдааны хязгаар
n	334	Оновчтой түүврийн хэмжээ

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Энд, t = Студентийн t тархалтын критик утга; w = түүврийн тодорхой асуултанд харуулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг; N = эх олонлогийн хэмжээ; Δ = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг Δ хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.


Түүврийн оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон, эх олонлогийн хэмжээг 2014 онд Татварын ерөнхий газар (ТЕГ)-т тайлан өгсөн, идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тоогоор төлөөлүүлэн 2,525¹ гэж тооцвол оновчтой түүврийн хэмжээ 334 байхаар байна.

Өмнө дурдсан шалгуураар 332 ААН (үүнээс 258 буюу 76% нь гадаадаас шууд хөрөнгө оруулалттай, 74 нь буюу 24% гадаадаас зээлтэй компаниуд)-ийг түүвэрлэн, судалгааны асуулгыг хүргүүлсэн. Түүврийн эх олонлогийг төлөөлөх чадварыг шалгах зорилгоор эх

¹ Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн мэдээлэл.

олонлог болон түүвэрт сонгогдсон ААН-ийн эдийн засгийн салбарын ангиллыг харьцуулан Дүрслэл 1-т үзүүлэв.

Дүрслэл 1. Эх олонлог болон түүврийн салбарын харьцуулалт



ҮСХ-ны салбарын ангиллын дагуу худалдаа, машин засварын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нь эх олонлогийн дийлэнх буюу (53%), шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа эрхлэгчид (7%), уул уурхай, олборлолтын салбар (7%), барилга (7%), боловсруулах салбар (7%) -ийг эзэлж байгаа бол түүвэрт сонгогдсон ААН-ийн хувьд худалдааны салбар (37%), уул уурхай (13%), шинжлэх ухаан (7%), барилга (5%), боловсруулах салбар (2%) -ийг бүрдүүлж байгаа нь түүврийн бүтэц эх олонлогийг төлөөлж чадахыг илтгэж байна.

3. Судалгааны ирц

Түүвэрт сонгогдсон 332 ААН-д судалгааны асуулгыг хүргүүлэх, хүлээн авах ажлыг хоёр байгууллага хамтран гүйцэтгэсэн ба 113 ААН буюу 34% нь судалгааны асуулгыг бөглөн ирүүлж, 52% нь судалгаанд оролцохоос татгалзаж, 13% нь судалгааг ирүүлэх шаардлагагүй, хаяг, утас тодорхойгүй, татан буугдсан шалтгаанаар судалгаанд хамрагдаагүй болно.


Хүснэгт 1. Судалгааны ирц

№	Үзүүлэлт	Тоо	Хувь
	Судалгааг ирүүлсэн	113	34%
	<i>Үүнээс: Монголбанкны хүлээн авсан</i>	86	26%
	<i>Хөрөнгө Оруулалтын Газрын хүлээн авсан</i>	27	8%
	Судалгааг ирүүлээгүй	173	52%
	Судалгааг ирүүлэх шаардлагагүй, татан буугдсан	10	3%
	Утас, хаяг тодорхойгүй	33	10%
	Судалгаанд сонгогдсон нийт ААН-үүдийн тоо	332	100%

Судалгааны ирц ердөө 34% байгаа боловч тэдгээр ААН-ийн хөрөнгө оруулалтын гадаад гүйлгээг нийт түүвэрт сонгогдсон ААН-ийн гүйлгээнд харьцуулан (Дүрслэл 2) үзвэл статистикийн ач холбогдол бүхий мэдээлэл байна. Түүврийн 52% нь судалгаанд оролцохоос

татгалзснаас үзэхэд цаашид статистикийн ач холбогдлыг олон нийтэд сурталчилан таниулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дүрслэл 2. Судалгааны дүнгийн Нийт түүвэрт эзлэх хувийн жин²



4. Судалгааны асуулга

Судалгааны асуулгыг ОУВС-гийн Төлбөрийн тэнцлийг боловсруулах 6 дугаар аргачлал, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позицйн судалгааны гарын авлага болон бусад хөгжингүй улс орнууд (АНУ, Австрали зэрэг)-ын төвбанк, статистикийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын судалгааны маягтад үндэслэн боловсруулсан ба дараах дэлгэрэнгүй мэдээллийг олж авахыг зорив. Үүнд:

1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ээдийн өмч)
2. Гадагш хийсэн шууд хөрөнгө оруулалт (хөрөнгө)
3. Худалдсан өрийн бичиг (өр төлбөр)
4. Худалдан авсан өрийн бичиг (хөрөнгө)
5. Зээл (өр төлбөр)
6. Зээл (хөрөнгө)
7. Худалдааны зээлийн өглөг (өр төлбөр)
8. Худалдааны зээлийн авлага (хөрөнгө)
9. Гадаадын банкин дах харилцах, хадгаламжийн данс
10. Бусад хөрөнгө оруулалт (хөрөнгө, өр төлбөр)
11. Дериватив
12. Хөрөнгө оруулалтын орлого, зардал
13. Ашгийн мэдээлэл
14. Хараат, Охин компаний мэдээлэл.

² ТТ-1 мэдээ ирүүлдэггүй ААН-ийн хөрөнгө оруулалт, зээлийн гүйлгээнд судалгаанд хамрагдсан ААНБ-уудын гүйлгээний дүнд эзлэх хувь.

Ш. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан 113 аж ахуйн нэгжийн мэдээллийг нэгтгэвэл:

- Гадаад актив буюу гадагш хийсэн хөрөнгө оруулалт 2013 онд 5.5 сая, 2014 онд 6.8 сая, 2015 оны эхний хагаст 11.7 сая ам.долларын үлдэгдэлтэй,
- Гадаад пассив буюу гаднаас татсан хөрөнгө оруулалт 2013 онд 543.6 сая, 2014 онд 742.1 сая, 2015 оны эхний хагаст 757.3 сая ам.долларын үлдэгдэлтэй,
- Хөрөнгө оруулалтын голлох эх үүсвэр нь хөрөнгө оруулагчийн зээл, худалдааны өглөг хэлбэртэй, багцын болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн хөрөнгө оруулалт аж ахуйн нэгжүүдэд байхгүй байна.

Хүснэгт 2. Судалгааны нэгдсэн үр дүн (мян.ам.доллараар)

Үзүүлэлт	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
Гадаад актив	5,489	6,824	11,725	24%	72%
Шууд хөрөнгө оруулалт	581	-	-	-100%	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	-	-	-		
Өрийн хэрэгсэл	581	-	-	-100%	
Бусад хөрөнгө оруулалт	4,909	6,824	11,725	39%	72%
Зээл	56	87	87	55%	0%
Худалдааны зээл	2,543	3,566	8,020	40%	125%
Харилцах хадгаламж	102	522	542	411%	4%
Бусад актив	2,208	2,649	3,076	20%	16%
Гадаад пассив	543,644	742,081	757,338	37%	2%
Шууд хөрөнгө оруулалт	359,800	502,653	531,434	40%	6%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	122,477	184,683	196,967	51%	7%
Орлогын дахин хөрөнгө оруулалт	(57,161)	(80,795)	(102,108)	41%	26%
Өрийн хэрэгсэл	294,483	398,765	436,576	35%	9%
Бусад хөрөнгө оруулалт	183,845	239,428	225,904	30%	-6%
Зээл	146,046	197,732	183,724	35%	-7%
Худалдааны зээл	3,349	4,268	9,052	27%	112%
Бусад пассив	34,449	37,428	33,128	9%	-11%
Цэвэр позиц	(538,155)	(735,257)	(745,613)	37%	1%

2013-2015 оны эхний хагас жилийн хооронд өссөн дүнгээр нийт 24.0 сая ам.долларын актив, 2,043.1 сая ам.долларын пассивын мэдээллийг хүлээн авсан ба үүнээс 1,521.6 сая ам.долларын пассивын мэдээлэл одоогийн зарлагдсан ГХОП-т бүртгэгдсэн байна.

Өөрөөр хэлбэл, энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэснээр 2013-2015 оны эхний хагас жилийн байдлаарх ГХОП-ийн актив өссөн дүнгээр 24.0 сая ам.доллараар, пассив 521.5 сая ам.доллараар тус тус нэмэгдэж статистикийн хамрах хүрээ сайжирсан. Дараах хуудаснаас хөрөнгө оруулалтын актив, пассивын төрөл хэлбэр тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

1. Шууд хөрөнгө оруулалт

1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө


ААН-үүд нь гадаадын компаниудын дүрмийн санд хөрөнгө оруулалт хийгээгүй, харин гадаадаас татсан хөрөнгө оруулалтийн хэмжээ 2013 онд 122.5 сая байсан бол 2014 оны эцэст 184.7 сая ам.долларт хүрч 51%-иар өсчээ. Энэ дүн 2015 оны эхний хагас жилийн байдлаар 197.0 сая ам.доллар болж өсөлтийн хурд саарсан байна.

Хүснэгт 3. ГХО-тай ААН-ийн эздийн өмчийн өөрчлөлт (мян.ам.доллараар)

Эздийн өмч	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1. Хувьцаат капитал	70,478	108,133	120,070	53%	11%
2. Нэмж төлөгдсөн капитал	977	8,197	9,223	739%	13%
3. Дахин үнэлгээний нэмэгдэл	1,742	1,633	2,222	-6%	36%
4. Эздийн өмчийн бусад хэсэг	49,279	66,720	65,452	35%	-2%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	122,477	184,683	196,967	51%	7%

Дээрх хөрөнгө оруулалтыг улсаар нь ангилан үзвэл БНХАУ (36-41%), БНСУ (1-15%), Канад (13-23%), Люксембург (8-18%), АНУ (6-11%), Сингапур (1-6%) эзэлж, хөрөнгө оруулагч улсын жин харьцангуй тогтвортой байна.

Дүрслэл 3. Хувь нийлүүлсэн хөрөнгө, улсаар




Хүснэгт 4. Хувь нийлүүлсэн хөрөнгө, улсаар (мян.ам.доллараар)

№	Улс	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1	БНХАУ	43,791	76,108	74,401	74%	-2%
2	Солонгос	1,791	25,119	29,806	14x	19%
3	Канад	28,071	25,526	25,026	-9%	-2%
4	Люксембург	21,790	15,462	22,194	-29%	44%
5	АНУ	13,317	11,047	12,158	-17%	10%
6	Сингапур	1,498	9,494	11,624	6.3x	22%
7	Итали	2,059	4,972	4,782	2.4x	-4%
8	Хонг Конг	3,134	4,875	4,687	56%	-4%
9	Англи	163	4,231	4,070	26x	-4%
10	Япон	2,802	2,757	3,331	-2%	21%
11	Бусад	4,062	5,091	4,889	25%	-4%
	Нийт	122,477	184,683	196,967	51%	7%

Хувь нийлүүлсэн хөрөнгийг ААН-ийн үйл ажиллагааны салбараар ангилан үзвэл уул уурхай, олборлох үйлдэрлэлд хамгийн их хувь буюу (41-51%), дараагаар нь гадаад худалдааны салбар (18-20%), геологи хайгуул, уул уурхайн судалгааны чиглэлд (9-13%), барилгын салбар (1-6%), санхүүгийн салбар (5-7%) эзлэх ба тайлант хугацааны туршид уул уурхай, геологи, хайгуулын салбарын хөрөнгө оруулалтын хувийн жин буурч, гадаад худалдаа, боловсруулах үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулалтын өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгө, салбараар



Хүснэгт 5. Хувь нийлүүлсэн хөрөнгө, салбараар (мян.ам.доллараар)

№	Салбар	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1	Уул уурхай, олборлох үйлдвэр	62,048	76,173	86,844	23%	14%
2	Гадаад худалдаа	22,421	35,535	39,461	58%	11%
3	Боловсруулах үйлдвэр	2,054	22,273	21,421	11x	-4%
4	Геологи, хайгуулын үйлчилгээ, уул уурхайн судалгаа шинжилгээ	15,331	18,321	17,896	20%	-2%
5	Барилга	1,324	10,822	10,467	8x	-3%
6	Санхүү, даатгалын үйлчилгээ	8,470	7,722	7,428	-9%	-4%
7	Тээвэр, агуулахын аж ахуй	7,543	6,628	6,375	-12%	-4%
8	Санхүүгийн зуучлал	642	1,625	1,702	2.5x	5%
9	Цахилгаан, эрчим хүч үйлдвэрлэл, ус хангамж	456	401	386	-12%	-4%
10	Бусад	2,190	5,182	4,988	2.4x	-4%
	Нийт	122,477	184,683	196,967	51%	7%

**1.2. Орлогын дахин хөрөнгө оруулалт**

Судалгаагаар ААН-үүдийн гадаадын хөрөнгө оруулагчид ногдох алдагдлын хэмжээ 2013 онд 13.7 сая, 2014 онд 23.6 сая, 2015 оны эхний хагаст 21.3 сая ам.доллар байх ба улсаар нь авч үзвэл Канад, АНУ, ОХУ, Итали, БНСУ-аас хөрөнгө оруулалттай ААН-үүд сүүлийн хоёр жилд үйл ажиллагааны ашигтай ажилласан бол Австрали, БНХАУ, Британий Виржин арлууд, Нидерландын хөрөнгө оруулалттай ААН-үүд алдагдалтай байжээ.

Хүснэгт 6. Орлогын дахин хөрөнгө оруулалт, улсаар (мян.ам.доллараар)

№	Улс	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1	Канад	(2,102)	1,391	3,111	-166%	124%
2	АНУ	1,438	3,235	2,658	125%	-18%
3	ОХУ	1,100	1,014	715	-8%	-29%
4	Итали	2,522	824	511	-67%	-38%
5	БНСУ	1,718	2,504	430	46%	-83%
6	Нидерланд	(467)	(1,065)	(626)	128%	-41%
7	Британийн Виржин Арлууд	(1,937)	(2,152)	(1,810)	11%	-16%
8	БНХАУ	(544)	(3,324)	(4,380)	511%	32%
9	Австрали	(16,701)	(21,625)	(20,695)	29%	-4%
10	Бусад	1,239	(4,436)	(1,227)	-458%	-72%
Нийт		(13,733)	(23,634)	(21,313)	57%	4%

Эдийн засгийн салбарын ангиллаар нь харвал гадаад худалдаа, санхүүгийн зуучлал, даатгал, тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд ашигтай, харин уул уурхай, барилга, геологи, хайгуулын үйлчилгээ, боловруулах үйлдвэрийн салбарууд алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 7. Орлогын дахин хөрөнгө оруулалт, эдийн засгийн салбараар (мян.ам.доллараар)

№	Салбар	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1	Гадаад худалдаа	(1,028)	306	3,603	-130%	1078%
2	Санхүүгийн зуучлал, даатгал	1,418	(279)	277	-120%	-199%
3	Тээвэр, агуулахын аж ахуй	372	702	56	89%	-92%
4	Боловсруулах үйлдвэр	(326)	(896)	(486)	175%	-46%
5	Геологи, хайгуулын үйлчилгээ, уул уурхайн судалгаа/шинж-гээ	(3,310)	(3,739)	(1,769)	13%	-53%
6	Барилга	64	538	(1,417)	739%	-363%
7	Уул уурхай, олборлох үйлдвэр	(11,090)	(19,861)	(21,150)	79%	6%
8	Бусад	166	(406)	(427)	-344%	5%
Нийт		(13,733)	(23,634)	(21,313)	57%	4%

ГХОП-т орлогын дахин хөрөнгө оруулалтыг хуримтлагдсан дүнгээр нь тусгах шаардлагатай тул 2013 оны үлдэгдлийг ААН-ийн хуримтлагдсан ашгаар төлөөлүүлж, харин 2014, 2015 оны үлдэгдлийг судалгааны явцад олж авсан дээрх үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдлын мэдээлэлд үндэслэн тооцоход 2013 онд -57.2 сая, 2014 онд -80.8 сая, 2015 оны эхний хагас жилийн байдлаар -102.1 сая ам.доллар байна.

Хүснэгт 8. Орлогын дахин хөрөнгө оруулалтын үлдэгдэл (мян.ам.доллар)

Үзүүлэлт	2013	2014		2015	
	Үлдэгдэл (1)	Гүйлгээ (2)	Үлдэгдэл (3=1+2)	Гүйлгээ (4)	Үлдэгдэл (5=3+4)
Орлогын дахин хөрөнгө оруулалт	(57,161)	(23,634)	(80,795)	(21,313)	(102,108)

1.3. Өрийн хэрэгсэл


ААН-ийн гадаадын шууд хөрөнгө оруулагчдаасаа авсан бусад санхүүжилтийг өрийн хэрэгсэлд тооцон бүртгэдэг. Судалгаагаар өрийн хэрэгслийн өглөг 2013 онд 294.0 сая, 2014 онд 298.8 сая, 2015 оны эхний хагас жилд 436.6 сая ам.доллар байх бөгөөд хугацааны хувьд 2013 онд 66%, 2014 онд 66%, 2015 оны байдлаар 65% нь урт хугацаанд эргэн төлөгдөхөөр байна.

Хүснэгт 9. Өрийн хэрэгсэл (мян.ам.доллараар)

№	Өрийн хэрэгсэл	Хугацаа	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
1	ШХО-гчаас авсан	Богино	58,974	88,281	112,419	50%	27%
		Урт	131,009	179,552	191,914	37%	7%
2	Холбоотой ААН-с авсан	Богино	7,034	5,022	5,587	-29%	11%
		Урт	55,882	77,744	83,368	39%	7%
3	Худалдааны зээлээрх	Богино	34,894	41,076	36,137	18%	-12%
		Урт	6,109	7,089	7,150	16%	1%
Нийт		Богино	100,902	134,379	154,143	33%	15%
		Урт	193,000	264,386	282,432	37%	7%
		Нийт	293,902	398,765	436,576	36%	9%


Шууд хөрөнгө оруулагч (толгой компани)-аас авсан санхүүжилт тайлант хугацаанд дунджаар 254.0 сая ам.доллар, нийт өрийн хэрэгслийн 67%-ийг эзэлж байсан бол холбоотой ААН (шууд болон дам хэлбэрийн хөрөнгө оруулагч)-ээс авсан санхүүжилт дунджаар 78.0 сая ам.доллар (21%), худалдаанаас үүссэн өглөг дунджаар 44.0 сая ам.доллар (12%) байна.

Дүрслэл 5. Өрийн хэрэгсэл, хугацаагаар



2015 оны хагас жилийн байдлаарх нийт өрийн хэрэгслийн үлдэгдлийг зээлдүүлэгч улсаар нь ангилбал Сингапур 109.1 сая ам.доллар буюу нийт өрийн хэрэгслийн 25%, БНХАУ 79.5 сая ам.доллар (18%), Британийн Виржин арлууд 70.1 сая ам.доллар (14%), Австрали (9%), БНСУ (9%), Япон (5%), Хонг Конг (5%)-ийг эзэлж дийлэнхийг бүрдүүлжээ.

Дүрслэл 6. Өрийн хэрэгсэл, улсаар (2015.06.30)



Дүрслэл 7. Өрийн хэрэгсэл, салбараар (2015.06.30)



Салбарын хувьд уул уурхай, олборлолтын салбар дахь өрийн хэрэгслийн үлдэгдэл 175.3 сая ам.доллар (40%), гадаад худалдаа 115.4 сая ам.доллар (26%), барилга 34.6 сая ам.доллар (8%), үл хөдлөх хөрөнгийн худалдаа 20.8 сая ам.доллар (5%), санхүү, даатгал 16.1 сая ам.доллар (4%), геологи, хайгуул 13.6 сая ам.доллар (3%) тус тус байна.

2. Багцын хөрөнгө оруулалт

Судалгаагаар ААН-үүд нь эдийн засгийн харьяат бустай багцын хөрөнгө оруулалт буюу дүрмийн сангийн 10%-иас хэтрэхгүй хувьцаа, үнэт цаас, өрийн бичгээрх ажил гүйлгээ хийгээгүй гэсэн хариултыг өгсөн байна. Цаашид багцын хөрөнгө оруулалтын мэдээллийг брокер, дилерийн компаниудаас тусгайлсан маягтаар авах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

3. Бусад хөрөнгө оруулалт

Энэ бүлэгт ААН-үүдийн шууд болон багцын хөрөнгө оруулалтаас бусад гадаад зээл, худалдааны зээл болон гадаадын банкинд байршуулсан харилцах, хадгаламжийг бүртгэнэ.

3.1. Худалдааны зээл

ААН-үүдийн гадаад худалдааны авлага богино хугацаат 1 жил ба түүнээс доош хугацаанд эргэн төлөгдөх бол өглөгийн 81% нь богино хугацаат, 19% нь урт хугацаатай байна. Авлага нь импортын урьдчилгаа төлбөр, төлбөр нь хийгдээгүй экспортын ачилттай холбоотой бол өглөг нь экспортын урьдчилгаа төлбөр, төлбөр нь хийгдээгүй байгаа импортын худалдан авалттай холбоотой үүсдэг байна.

Хүснэгт 10. Худалдааны зээл (мян.ам.доллараар)

Үзүүлэлт	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
Актив	2,543	3,566	8,020	40%	125%
Богино	2,543	3,566	8,020	40%	125%
Урт	-	-	-		
Пассив	807	702	1,031	-13%	47%
Богино	807	433	839	-46%	94%
Урт		269	193		-28%
Цэвэр	1,736	2,864	6,989	65%	144%

3.2 Зээл


Судалгаагаар ААН-үүдийн гадаадын банк, санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын хамааралгүй компаниудаас авсан зээлийн үлдэгдэл 2013 онд 146.0 сая ам.доллар, 2014 онд 35%-иар өсч 197.7 сая ам.доллар, 2015 онд 7%-аар буурч 183.7 сая ам.доллар болжээ.

Хүснэгт 11. Зээл (мян.ам.доллараар)


№	Улс	2013	2014	2015.06.30	2014/13	2015/14
	Актив	56	87	87	55%	0%
1	БНХАУ	56	87	87	55%	0%
	Пассив	146,046	197,732	183,724	35%	-7%
1	Англи	24,800	26,014	22,668	5%	-13%
2	АНУ	13,264	6,629	21,341	101%	-20%
3	Бельги	5,400	5,400	5,400	0%	0%
4	БНСУ	10,000	15,000	13,000	50%	-13%
5	БНХАУ	33,907	65,700	60,693	90%	-7%
6	Британий Виржин Арлууд	2,280	8,100	6,780	255%	-16%
7	Герман	15,293	15,497	15,090	1%	-3%
8	Люксембург	5,000	4,500	5,000	-10%	11%
9	Сингапур	5,841	11,428	14,468	96%	27%
10	Франц	23,574	10,500	7,918	-55%	-25%
11	Шинэ Зеланд	-	-	480		
12	Япон	6,122	8,898	9,813	45%	10%

Зээл олгосон улсыг авч үзвэл БНХАУ-аас авсан зээл 60.7 сая ам.доллар (33%), Англи 22.7 сая (13%), АНУ 21.2 сая (12%), Герман 15.1 сая (8%), Сингапур 14.5 сая (8%), үлдсэн 49.5 сая ам.долларыг бусад улсын зээл эзлэх бол салбарын хувьд уул уурхайн, олборлолтын салбарт (39%), гадаад худалдааны салбарт (38%), зочид буудал, зоогийн газар (12%), санхүү, даатгал салбарт (5%), үлдсэн 6% нь бусад салбарт хамаарч байна.

Дүрслэл 8. Зээл, улсаар (2015.06.30)



Дүрслэл 9. Зээл, салбараар (2015.06.30)



3.2. Харилцах хадгаламж

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн гадаадын банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 2013 онд 0.1 сая, 2014 онд 0.5 сая, 2015 онд 6.4 сая ам.доллар, улсын хувьд БНХАУ банкинд голчлон байршиж байна.



3.3. Бусад актив, пассив

Энэ бүлэгт дээр дурдсан өрийн хэрэгслээс бусад хэлбэрийн өглөг, авлагыг бүртгэх ба судалгаанд хамрагдсан ААН-үүдийн бусад авлага 2013 оны эцэст 2.2 сая, 2014 онд 2.6 сая, 2015 оны эхний хагаст 16% өсч 3.1 сая ам.долларт хүрсэн бол өглөг 2013 онд 34.4 сая, 2014 онд 37.4 сая, 2015 оны эхний хагаст 33.1 сая ам.доллар болж тус тус өссөн байна.

4. Гадаад хөрөнгө оруулалтын позицид орох өөрчлөлт

Судалгаанд хамрагдсан 113 ААН-ийн мэдээллийг нэгтгэн одоогийн зарлагдсан статистикт бүртгэгдсэн эсэхийг шалгахад өссөн дүнгээр 24 сая ам.долларын актив, 521.6 сая ам.долларын пассив (судалгааны дүнгийн 26%) нь бүртгэгдээгүй байна. Дүнг холбогдох тайлант жил, улирлын статистикт тусгах шаардлагатай.

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позицийн 2015 оны 2 дугаар улирлын шинэчилсэн гүйцэтгэлийг харвал актив 0.3%-иар, пассив 0.7%-иар тус тус нэмэгдэхээр байна.

Хүснэгт 12. Гадаад хөрөнгө оруулалтын позиц (мян.ам.доллараар)

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

(2015 оны 2 дугаар улирлын байдлаар)

				/Сая ам.доллар/			
А. ГАДААД АКТИВ	3,671.5	0.3%	↗	Б. ГАДААД ПАССИВ	28,180.9	0.7%	↗
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	375.4	-		6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	16,803.3	0.4%	↗
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	365.7	-		6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин оруулалт	5,923.4	-4.7%	✓
1.2 Бусад хөрөнгө	9.7	-		6.2 Бусад хөрөнгө	10,879.8	3.4%	↗
2. Багцын хөрөнгө оруулалт	315.6	-		7. Багцын хөрөнгө оруулалт	3,580.5	-	
2.1 Хөрөнгийн хувьцаа	245.7	-		7.1 Хөрөнгийн хувьцаа	94.0	-	
2.2 Өрийн бичиг	69.9	-		7.2 Өрийн бичиг	3,486.5	-	
3. Санхүүгийн дериватив	2.4	-		8. Санхүүгийн дериватив	5.5	-	
4. Бусад хөрөнгө оруулалт	1,292.6	0.9%	↗	9. Бусад хөрөнгө оруулалт	7,791.7	1.6%	↗
4.1 Худалдааны зээл	619.0	1.3%	↗	9.1 Худалдааны зээл	451.9	-	
4.2 Зээл	52.3	0.2%	↗	9.2 Зээл	5,304.5	2.4%	↗
4.2.1 Төв банк	0.0	-		9.2.1 Төв банк	68.6	-	
4.2.2 Засгийн газар	0.0	-		9.2.2 Засгийн газар	2,056.9	-	
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	50.1	-		9.2.3 Банк санхүүгийн байгууллага	888.6	-	
4.2.4 Аж ахуйн нэгж	2.1	4.3%	↗	9.2.4 Аж ахуйн нэгж	2,290.4	5.8%	↗
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	618.2	0.1%	↗	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	1,921.3	-	
4.4 Бусад актив	3.1	-		9.4 Бусад пассив	114.0	-	
5. Нөөц актив	1,685.7	-		В. ПОЗИЦ	(24,509.4)	5.8%	✓
5.1 Мөнгөжсөн алт	83.5	-		10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(16,427.9)	-	
5.2 Зээлжих тусгай эрх	60.4	-		11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(3,264.9)	-	
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.0	-		12. Санхүүгийн дериватив (цэвэр)	(3.1)	-	
5.4 Бэлэн валют ба харилцах	1,260.4	-		13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(6,499.1)	-	
5.5 Үнэт цаас	281.4	-		14. Нөөц актив	1,685.7	-	
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0	-					
5.7 Бусад нөөц актив	0.0	-					

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгааны түүвэрт нийт 332 аж ахуйн нэгжийг сонгосноос 113 ААН судалгааны асуулгыг бөглөн ирүүлсэн нь нийт түүврийн 34%-ийг эзэлж байна. Эдгээр байгууллагын тоон мэдээллийг ашиглан дараах үр дүнг тооцлоо.

Судалгааны үр дүнд:

- Гадаад активын үлдэгдэл 2013 онд 5.5 сая, 2014 онд 6.8 сая, 2015 оны эхний хагас жилийн байдлаар 11.7 сая ам.доллараар тус тус нэмэгдэх ба энэ нь худалдааны зээлээс үүссэн авлагын мэдээлэлтэй холбоотой байна.
- Гадаад пассивын үлдэгдэл 2013 онд 141.2 сая, 2014 онд 189.4 сая, 2015 оны 2-р улиралд 190.9 сая ам.доллараар тус тус нэмэгдэхээр байна. Данс тус бүрээр нь харвал, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүртгэл буурч, харин өрийн хэрэгсэл, бусад хөрөнгө оруулалтын өр төлбөрийн үлдэгдэл өссөхөөр байна.

Үзүүлэлт	2013	2014	2015Q2
Нийт өөрчлөлт	141.2	189.4	190.9
ШХО-Хувь нийлүүлсэн хөрөнгө	(139.0)	(202.8)	(190.5)
ШХО-Орлогын дахин х/о	(57.2)	(80.8)	(102.1)
ШХО-Өрийн хэрэгсэл	247.8	326.7	358.2
Бусад хөрөнгө оруулалт	89.6	146.3	125.3

- Судалгааны үр дүнд Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн 2015 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд гадаад актив 4.4 сая ам.доллараар нэмэгдэж, гадаад пассив 40.0 сая ам.доллараар буурах бөгөөд урсгалаар нь тооцвол, орох урсгал 21.6 сая ам.доллараар, гарах урсгал 64.9 сая ам.доллараар тус тус нэмэгдэснээр алдаа ба орхигдуулга 43.3 сая ам.доллараар буурч байна.

Цаашид хийгдэх ажил:

1. Түүврийн мэдээллээс өндөр дүнтэй ажил гүйлгээтэй ААН-үүдээс ТТ-1 мэдээ авах,
2. Тайлант хугацааны ГХОП-д өөрчлөлтийг оруулах,
3. Одоогийн хууль эрхзүйн хүрээнд ААН нь судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцож байгаа тул судалгааны ирц хангалтгүй байна. Иймд статистик мэдээлэл цуглуулахтай холбоотойгоор хууль эрхзүйн орчинг сайжруулах боломжийг судлах,
4. Гадаад хөрөнгө оруулалтын статистик мэдээллийн санг сайжруулах ажилд холбогдох яам, агентлагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр санал хүргүүлж шийдвэрлүүлэх.



V. Хавсралт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн нэрс

1	АБТС ББСБ	32	Жин Жиэн Мин Гүө Жи
2	Агммайнинг	33	Занаду-Эксплорейшн Монголиа
3	Ай Ти Жи Эм	34	Зон хэн юу тиан
4	Айбексмонголиа	35	Зун мен
5	Айдинерглобал	36	Илк
6	Англо Американ Дэвэллопмент	37	Индустр
7	Арш	38	Ихсүндэр Констракшн
8	Аспайр Монгол	39	Иххаадын Цуваа
9	Ашид Мөнхийн Зам	40	Камминс Монголиа Инвестмент
10	Баян Ундрал Эрдэс Групп	41	Капитал Континент Инвестмент
11	Би Ар Си Глору Консалтинг	42	Кортиновис
12	БСБ сервис	43	Лоропьяна Монгол
13	Бүрд Констракшны Гэр Хорооллын Дахин Төлөвлөлт	44	М Си Эс Кокакола
14	Бүрд пропертиз	45	Майнс-Ап
15	Бүрд холдинг	46	Макмаон Монголиа
16	Бэрэн металл	47	Монголиа Гладвил Увс Петролеум
17	Вагнер Ази Лизинг	48	Монголиа Жун Жиэн Цай
18	Ван-Үрс	49	Монголиан Минералз Питии
19	Витафит-Инвест	50	Монголиа проперти Девелопмент
20	Вульф петролеум	51	Монгол металс
21	Гоу Жи Мао И	52	Монгол Субару Автомашин
22	Грийн сити	53	Мон шибасаки
23	Дархан нэхий	54	Монь-Ивээл
24	Денисон Майнис Монголиа	55	Морнингстар Лэнд
25	Дехор	56	Мөнхийн Баян Гал
26	Ди Кю И Интернейшнл Монгол	57	Мөнхнаран Инвестмент Монголиа
27	Дижитал сэнтр	58	Мөнххада
28	Домус пропертиз	59	МЦУУ
29	Дэү секьюритис Монгол	60	Мэлбүрикапитал Монголиа
30	Жени Ойл Шейл Монголиа	61	Мэргэван
31	Жиансүянг Жөүхэнг Юүэн	62	Нарансансар
		63	НВЦ



64	Номадик Экспедишнз Монголия	90	Хас лизинг
65	Нью Яармаг Хаусинг Прожект	91	Хис монголиа
66	Отгонтэнгэр Групп	92	Хорскинг Инвестмент
67	Риотинто Холдингс	93	Хьундай моторс Монгол
68	Санкосоолар Монголиа	94	Хэрлэн Онон Туул
69	Сика Монголиа	95	Хэрлэн-Импэкс
70	Сөүлсэниорс Монголиа	96	Цагаан-Өвөлжөө
71	Стандарт Проперти Групп	97	Цамхаг Гүүр
72	Сэндвикмонголиа	98	Централ Эйшиан Цемент
73	Сэнжсант	99	Чайнаметалуржикал Тиангонг Констракшн Монголиа
74	Тайкүүндепот Монголиа		
75	Тайшэн девелопмент	100	Чоно финанс
76	Терра-Энержи	101	Чуангс-Эдэлвайз
77	Ти Ди Би Лизинг	102	Шанжин-Орд
78	Ти Эф Ти Эф	103	Шар Мөрөн Хатан Гол
79	Трансвест Монголиа	104	Шарын Гол
80	Тулгат-Өргөө	105	Шунхлай
81	Туул-Интернэшнл	106	Шунхлай говь
82	Туушинзочид Буудал	107	Эбердигм Монгол
83	Тэдмэнт	108	Эжбалей
84	Уул Уурхайн Үндэсний Олборлогч	109	Эм Си Ти Ти
85	Уулс заамар	110	Эн Эй Ар
86	Фрэйвиллэ Жевелри	111	Эрдэнэ Монгол
87	Фужи-Алтай	112	Эс Девелопмент
88	Ханбүргэдэй	113	Эс Эл Эс Беарингс Монголиа
89	Ханшашир		